



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Ж.Самбуугийн гудамж-30, Бага тойруу,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201
Утас: 32-01-26, Факс: (976-11) 31-93-35,
Цахим шуудан: info@erc.gov.mn

Цахим хуудас: erc.gov.mn

2024.11.15 № 01/1026

танай _____-ны № _____-т

ЦАХИЛГААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛУУДАД

Хэрэглэгчийн тарифт өөрчлөлт оруулахтай
холбоотой бэлтгэл ажил хангах тухай

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хурлаар Төв, Өмнөд, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон цахилгаан эрчим хүч хэрэглэгч үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхөд борлуулах цахилгааны тариф, чадлын тарифыг баталсан тогтоолуудыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгэснийг хавсралтаар хүргүүлж байна.

Хэрэглэгчдэд борлуулах цахилгааны батлагдсан тарифуудыг Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлэгдсэн өдөр буюу 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллах, холбогдох бэлтгэл ажлыг хангаж, борлуулалтын программ хангамжид дараах өөрчлөлтүүдийг оруулах арга хэмжээг авна уу. Үүнд:

1.Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, зарим аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тарифын ангиллаас интернэт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид хасагдаж бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тарифын ангилалд шилжсэн. Харин үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд борлуулах цахилгааны тарифын шинэ ангилал нэмэгдсэн;

2.Энгийн болон цагийн ялгаварт 3 тарифт тоолууртай үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф болон чадлын тарифыг сарын нийт хэрэглээний 5,000.0 кВт.ц болон 200,000.0 кВт.ц-ын шатлалгүй болгосон;

3.Нийт хэрэглэгчдэд мөрдөж буй сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифын тогтоолыг хүчингүй болгосонтой холбоотой Төв, Өмнөд, Алтай-Улиастайн бүсийн цахилгаан эрчим хүч хэрэглэгч үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхөд борлуулах цахилгааны тарифт дэмжих тариф орсон байдлаар мөрдөнө;

4.Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифт өөрчлөлт оруулаагүй ба дэмжих тариф орсон байдлаар шинэчлэн батлагдсан;

5.Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг ангиллаас хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид сарын нийт хэрэглээний шатлалыг Дархан, Эрдэнэт хотуудад 75 кВт.ц, бусад аймаг, сумуудад 50 кВт.ц байсныг Улаанбаатар хоттой ижил буюу 100 кВт.ц болгосон;

6.Айл өрхөд борлуулах цахилгааны тарифын ангилалд цагийн ялгаварт 3 тарифт тоолуурын ангилал шинээр нэмэгдэж байгаагаас гадна энгийн тоолууртай, цагийн ялгаварт 2 болон 3 тарифт тоолууртай хэрэглэгчийн тарифын ангилал тус бүрт төлбөр тооцох сарын нийт хэрэглээний 0-150.0 кВт.ц хүртэл, 150.0-300.0 кВт.ц, 300.0 кВт.ц-аас их гэсэн 3 шатлалтай болсон;

7.Цагийн ялгаварт 2 болон 3 тарифт тоолууртай айл өрхийн сарын нийт хэрэглээний өдөр, орой, шөнийн цагийн хэрэглээнд эзлэх хувь хэмжээгээр 0-150.0 кВт.ц, 150.0-300.0 кВт.ц, 300.0 кВт.ц-аас их хэрэглээг хуваарилах байдлаар цахилгааны төлбөрийг тооцох; (Ахуйн хэрэглэгчийн цахилгааны хэрэглээг тооцсон жишээ тооцоог хавсралтаар үзүүлэв.)

8.Ахуйн хэрэглэгчийн суурь тарифын ангилал хэвээр мөрдөх зэрэг өөрчлөлтүүд орж байна.

Ахуйн хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний бодит өртөг, зардлын талаар мэдээллийг өгөх үүднээс үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны бодит өртөг зардлын мэдээллийг тусгасан төлбөрийн нэхэмжлэлийн загварыг хавсралтаар хүргүүлж байна.

Шаардлагатай нэмэлт мэдээллийг Хорооны Үнэ, тарифын газрын холбогдох мэргэжилтнүүдээс авна уу.

Хавсралт:

1.Төв, Өмнөд, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон цахилгаан эрчим хүч хэрэглэгч үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхөд борлуулах цахилгааны "Тариф батлах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 632 дугаар тогтоол, ... хуудастай.

2.Төв, Зүүн, Өмнөд, Баруун, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон цахилгаан эрчим хүч хэрэглэгч үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны чадлын "Тариф батлах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 636 дугаар тогтоол, ... хуудастай.

3.Цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон нийгмийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд борлуулах цахилгааны "Тариф батлах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 638 дугаар тогтоол, ... хуудастай.

4.Нэг сарын 350 кВт.ц-ийн цахилгаан хэрэглэдэг өрхийн хэрэглээг тоолуурын төрөл болон тарифын шатлалд харгалзах нийт хэрэглээнд эзлэх хувь хэмжээгээр өдөр, орой, шөнийн цагийн хэрэглээг хуваарилсан жишээ тооцоо, ... хуудастай.

5.Цахилгааны төлбөрийн нэхэмжлэлийн загвараар цагийн ялгаварт 2 тарифт тоолууртай ахуйн хэрэглэгчийн цахилгааны төлбөр тооцсон жишээ тооцоо, ... хуудастай.

ДАРГА



Э.ТҮВШИНЧУЛУУН

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны
11 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дугаар
албан бичгийн 1 дүгээр хавсралт




Ахуйн хэрэглэгчийн цахилгааны хэрэглээг тооцох жишээ тооцоо

Д/д	Ангилал	Сарын хэрэглээ, кВт.ц	Эзлэх хувь	Хэрэглээний шатлал					
				0-150 кВт.ц хүртэл	Эзлэх хувь	150-300 кВт.ц	Эзлэх хувь	300 кВт.ц их	Эзлэх хувь
1	Энгийн тоолууртай	350.0		150.0		150.0		50.0	
2	2 тарифт тоолууртай	350.0	100.0%	150.0	100%	150.0	100%	50.0	100%
	Өдөр 06:00-21:00	248.5	71.0%	106.5	71%	106.5	71%	35.5	71%
	Шөнө 21:00-06:00	101.5	29.0%	43.5	29%	43.5	29%	14.5	29%
3	3 тарифт тоолууртай	350.0	100.0%	150.0	100%	150.0	100%	50.0	100%
	Өдөр 06:00-17:00	175.0	50.0%	75.0	50%	75.0	50%	25.0	50%
	Орой 17:00-21:00	73.5	21.0%	31.5	21%	31.5	21%	10.5	21%
	Шөнө 21:00-06:00	101.5	29.0%	43.5	29%	43.5	29%	14.5	29%

Жич: Нэг сарын 350 кВт.ц-ийн цахилгаан хэрэглэдэг өрхийн хэрэглээг тоолуурын төрөл болон тарифын шатлалд харгалзах нийт хэрэглээнд эзлэх хувь хэмжээгээр өдөр, орой, шөнөөр тодорхойлно.

ҮНЭ, ТАРИФЫН ГАЗАР

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны
11 дүгээр сарын 15-ны өдрийн /15/ дугаар
албан бичгийн 2 дугаар хавсралт



ЦАХИЛГААНЫ ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР

Хэрэглэгчийн код: 100000001	Нэхэмжлэгч: "УБЦТС" ТӨХК
Овог:	Нэхэмжлэгчийн данс:
Нэр:	Борлуулалтын цикл: R1
Хаяг:	Хамрах хугацаа: 2024.11.01-2024.12.01
РД:	

Цахилгааны өртгийн талаар хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл

№	Төлбөрийн үзүүлэлт	Хэрэглэгчдэд худалдаж буй ЦЭХ-ний өртөг	Хэрэглээ	Бодит өртгөөр тооцсон ЦЭХ-ний төлбөр
		төг/кВт.ц	кВт.ц	төгрөг
1.1	Түлш, нүүрсний зардал	45.40		15,890.0
1.2	Үйлдвэрлэлийн зардал	129.40		45,290.0
1.3	Импортын зардал	23.60		8,260.0
1.4	Дамжуулалтын зардал	54.70	350.0	19,145.0
1.5	Түгээлт, хангалтын зардал	26.90		9,415.0
1	ЦЭХ-ний нийт өртөг, зардал	280.00		98,000.0
2	НӨАТатвар		10.0%	9,800.0
3	Өртгөөр тооцсон нийт төлбөр			107,800.0

Худалдаж авсан цахилгааны төлбөл зохих төлбөр /батлагдсан тарифаар/

№	Ангилал	Хэмжүүр дугаар	Тоолуурын заалт		Зөрүү	Коэф	Хэрэглээ (кВт.ц)	Тариф (төг/кВт.ц)	Төлбөр (төгрөг)	Орлого (төгрөг)	
			өмнөх	одоо							
1	Хэрэглэгчийн 2024.11.01 өдөр хүртэл хугацааны цахилгааны төлбөрийн үлдэгдэл:									15,800.0	
2	Энгийн тоолууртай										
	150 кВт.ц хүртэл	45045	0.0		0.0	1	0.0	175.00	-		
	151-300 кВт.ц	45045	0.0		0.0	1	0.0	256.00	-		
	300 кВт.ц дээш	45045	0.0		0.0	1	0.0	285.00	-		
	Нийт				0.0		0.0		-		
3	2 тарифт тоолууртай										
	Өдрийн хэрэглээ /06:00-21:00/										
	150 кВт.ц хүртэл	45046	0.0	106.5	106.5	1	106.5	182.00	19,383.0		
	151-300 кВт.ц	45046	0.0	106.5	106.5	1	106.5	225.00	23,962.5		
	300 кВт.ц дээш	45046	0.0	35.5	35.5	1	35.5	265.00	9,407.5		
	Орой, шөнийн хэрэглээ /21:00-06:00/										
	150 кВт.ц хүртэл	45046	0.0	43.5	43.5	1	43.5	147.00	6,394.5		
	151-300 кВт.ц	45046	0.0	43.5	43.5	1	43.5	160.00	6,960.0		
	300 кВт.ц дээш	45046	0.0	14.5	14.5	1	14.5	160.00	2,320.0		
	Нийт			350.0	350.0		350.0		68,427.5		
4	3 тарифт тоолууртай										
	Өдрийн хэрэглээ /06:00-17:00/										
	150 кВт.ц хүртэл	45047	0.0		0.0	1	0.0	170.00	-		
	151-300 кВт.ц	45047	0.0		0.0	1	0.0	190.00	-		
	300 кВт.ц дээш	45047	0.0		0.0	1	0.0	220.00	-		
	Оройн хэрэглээ /17:00-21:00/										
	150 кВт.ц хүртэл	45047	0.0		0.0	1	0.0	280.00	-		
	151-300 кВт.ц	45047	0.0		0.0	1	0.0	290.00	-		
	300 кВт.ц дээш	45047	0.0		0.0	1	0.0	300.00	-		
	Шөнийн хэрэглээ /21:00-06:00/										
	150 кВт.ц хүртэл	45047	0.0		0.0	1	0.0	113.00	-		
	151-300 кВт.ц	45047	0.0		0.0	1	0.0	113.00	-		
	300 кВт.ц дээш	45047	0.0		0.0	1	0.0	113.00	-		
	Нийт			0.0	0.0		0.0		-		
5	ЦЭХ-ний суурь төлбөр									3,200.0	
6	Цахилгааны төлбөр /НӨАТ-гүй/:						350.0	204.65	71,627.5		
7	НӨАТатвар							10%	7,162.8		
8	Цахилгааны нийт төлбөр: (6+7)									78,790.3	
9	Шөнийн тарифын хөнгөлөлт дүн:									17,242.0	
	Шөнийн тарифын хөнгөлөлт (100%)						101.5	154.43	15,674.5		
	150 кВт.ц хүртэл						43.5	147.00	6,394.5		
	151-300 кВт.ц						43.5	160.00	6,960.0		
	300 кВт.ц дээш						14.5	160.00	2,320.0		
	Шөнийн тарифын хөнгөлөлтөөс хэтэрсэн (50%)						0.0	80	-		
	НӨАТатвар							10%	1,567.5		
10	Нэгж өртгөөс тооцсон тарифын хөнгөлөлт - Тарифт тоолууртай									29,009.8	
10.1	Нэгж өртгөөр тооцсон төлбөр						350.0	280.00	98,000.0		
10.2	Айл өрхөд борлуулах цахилгааны дундаж тарифаар тооцсон төлбөр						350.0	204.65	71,627.5		
10.3	Нэгж өртөг, тарифын зөрүү (10.1-10.2)						350.0	75.35	26,372.5		
10.4	НӨАТатвар							10%	2,637.3		
11.1	Үйлчилгээний төлбөр									2,500.0	
11.2	Мэд.хүр. төлбөр									50.0	
11.3	НӨАТатвар (үйлч.)									255.0	
11.4	ТВ хураамж									1,100.0	
11.5	Холны хураамж									2,500.0	
11	Бусад төлбөрийн дүн: (11.1+11.2+11.3+11.4+11.5)									6,405.0	-
12	Төлбөл зохих нийт төлбөр (8+11-9)									67,963.3	
13	Хэрэглэгчийн төлсөн төлбөрийн дүн:										85,000.0
14	Эцсийн үлдэгдэл: (1+12-13)									(1,246.7)	

Санамж: Тооцоо гарснаас хойш 10 хоногийн дотор төлбөрөө төлөхүй тохиолдолд алданги тооцогдоно.
Тайлбар: Хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифт дэмжих тариф (Төвийн бүс - 23.79 төг/кВт.ц)-ыг оруулж тооцсон болно.
Лавлах утас: 70047004
Хугацаандаа төлбөрөө төлсөн танд баярлалаа



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.11.06 № 1/1640
танай 2024.11.01 -ны № 01/964 -т

**Улсын нэгдсэн бүртгэлд
бүртгэсэн тухай**

“Тариф батлах тухай” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 632, 633, 634, 635, 636, 637, 638, 639, 640, 641, 642, 643 дугаар тогтоолуудыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад доор дурдсанаар захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн дугаарт тус тус бүртгэн хүргүүлж байна. Үүнд:

1.“Тариф батлах тухай” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 632 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ~~...6970...~~ дугаарт;

2.“Тариф батлах тухай” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 633 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ~~...6971...~~ дугаарт;

3.“Тариф батлах тухай” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 634 дүгээр тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ~~...6972...~~ дугаарт;

4.“Тариф батлах тухай” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 635 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ~~...6973...~~ дугаарт;

5.“Тариф батлах тухай” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 636 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ~~...6974...~~ дугаарт;

6.“Тариф батлах тухай” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 637 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ~~...6975...~~ дугаарт;

7.“Тариф батлах тухай” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 638 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ~~...6976...~~ дугаарт;

8. "Тариф батлах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 639 дүгээр тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...~~6977~~... дугаарт;

9. "Тариф батлах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 640 дүгээр тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...~~6978~~... дугаарт;

10. "Тариф батлах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 641 дүгээр тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...~~6979~~... дугаарт;

11. "Тариф батлах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 642 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...~~6980~~... дугаарт;

12. "Тариф батлах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 643 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...~~6981~~... дугаарт.



О.АЛТАНГЭРЭЛ



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 632

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Төв, Өмнөд, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тарифыг 1 дүгээр хавсралтаар, айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 94, 98, 110, 114, 115 дугаар тогтоолууд, 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 504, 505, 510, 511 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

П.ТОВУУДОРЖ

Л.ДАШМЯГМАРЖАВ

Ц.НОРОВЖАМЦ

Д.ЦОГОО



1424011499

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн
632 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ
ЦАХИЛГААНЫ ТАРИФ**

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад борлуулах цахилгааны тарифыг (дэмжих тариф 23.79 төг/кВт.ц орсон, НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, зарим аж ахуйн нэгж, байгууллага Үүнд: Нүүрс олборлолт, боловсруулалт Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт Банк, банкны нэгж Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Криптовалют олборлох, үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч		
1.1	Энгийн тоолууртай	төг/кВт.ц	285.00
1.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	285.00
б	Оройн хэрэглээ /17.00 цагаас 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	476.00
в	Шөнийн хэрэглээ /22.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	160.00
2	Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч		
2.1	Энгийн тоолууртай	төг/кВт.ц	275.00
2.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	275.00
б	Оройн хэрэглээ /17.00 цагаас 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	437.00
в	Шөнийн хэрэглээ /22.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	160.00
3	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага		
3.1	Энгийн тоолууртай	төг/кВт.ц	265.00
3.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	265.00
б	Оройн хэрэглээ /17.00 цагаас 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	397.00
в	Шөнийн хэрэглээ /22.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	160.00

Тайлбар: Өдөр, орой, шөнийн тарифыг мөрдөх хугацааг тоолуурын цагаар тооцно.

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн
632 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

1. Айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (дэмжих тариф 23.79 төг/кВт.ц орсон, НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Энгийн тоолууртай		
а	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээг	төг/кВт.ц	175.00
б	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас их, 300 кВт.ц-аас ихгүй хэрэглээг	төг/кВт.ц	256.00
в	Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас их хэрэглээг	төг/кВт.ц	285.00
2	2 тарифт тоолууртай		
2.1	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 21.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	182.00
б	Орой, шөнийн хэрэглээ /21.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	147.00
2.2	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас их, 300 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 21.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	225.00
б	Орой, шөнийн хэрэглээ /21.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	160.00
2.3	Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас их хэрэглээг		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 21.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	265.00
б	Орой, шөнийн хэрэглээ /21.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	160.00
3	3 тарифт тоолууртай		
3.1	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	170.00
б	Оройн хэрэглээ /17.00 цагаас 21.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	280.00
в	Шөнийн хэрэглээ /21.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	113.00
3.2	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас их, 300 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	190.00
б	Оройн хэрэглээ /17.00 цагаас 21.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	290.00
в	Шөнийн хэрэглээ /21.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	113.00
3.3	Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас их хэрэглээг		
а	Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	220.00
б	Оройн хэрэглээ /17.00 цагаас 21.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	300.00
в	Шөнийн хэрэглээ /21.00 цагаас 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	113.00
4	Сарын суурь тариф	төг/сар	3,200.00

Тайлбар: Өдөр, орой, шөнийн тарифыг мөрдөх хугацааг тоолуурын цагаар тооцно.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 636

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Төв, Зүүн, Өмнөд, Баруун, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны чадлын тарифыг хавсралтаар баталсугай.

2.Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 508, 514 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

П.ТОВУУДОРЖ

Л.ДАШМЯГМАРЖАВ


Ц.НОРОВЖАМЦ

Д.ЦОГОО



1424011511

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн
636 дугаар тогтоолын хавсралт



**ТӨВ, ЗҮҮН, ӨМНӨД, БАРУУН, АЛТАЙ-УЛИАСТАЙН БҮСИЙН НЭГДСЭН
СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ЧАДЛЫН ТАРИФ**

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны чадлын тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, зарим аж ахуйн нэгж, байгууллага Үүнд: Нүүрс олборлолт, боловсруулалт Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт Банк, банкны нэгж Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Криптовалют олборлох, үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч	төг/кВт/сар	39,675.00
2	Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч	төг/кВт/сар	32,000.00
3	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/кВт/сар	15,500.00



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 638

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг хавсралтаар баталсугай.

2.Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг цахилгаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 106 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

П.ТОВУУДОРЖ

Л.ДАШМЯГМАРЖАВ

Ц.НОРОВЖАМЦ

Д.ЦОГОО



1424011517

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн
638 дугаар тогтоолын хавсралт



**ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ НЭГДСЭН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА ЗАЙЛШГҮЙ
ШААРДЛАГАТАЙ ХЭРЭГЛЭГЧДЭД МӨРДӨХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ**

1. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг (дэмжих тариф 23.79 төг/кВт.ц орсон, НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Энгийн тоолууртай		
а	Сарын нийт хэрэглээний 100 кВт.ц-аас ихгүй хэрэглээг	төг/кВт.ц	84.08
б	Сарын нийт хэрэглээний 100 кВт.ц-аас их хэрэглээг	төг/кВт.ц	105.18